

Монголын тусгаар тогтнол: Ноёдын үхэл

С.Чулуун (Doctor Ph.D)
МУИС-ийн Түүхийн тэнхмийн багш

Төрийн эрхэнд орсон хүн зодуулж үхдэг
Бурханы үгэнд орсон хүн өлсөж үхдэг
Эртний үзээс

Өгүүлэлийн товч утга: Уг өгүүлэлд ХХ зууны эхэн хагаст өрнөсөн Үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагч, тэргүүлэгчдийн хоорондын харилцаа, ихэнх улс төрийн зүтгэлтнүүдийн учир битүүлэг үхэл түүнд нөлөөлсөн гадаад хийгээд дотоод хүчин зүйлийн асуудлыг түүхийн архивын баримт бичгүүдэд тулгуурлан тодруулахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Ноёд хоорондын зөрчил, учир битүүлэг үхэл, тусгаар тогтнол

Түүхийн шинэ эрин ХХ зууны эхэн болоход Монголчууд өөрийн тусгаар тогтнолын төлөө нэгдэн тэмцэж эхэлсэн юм. Монголын ноёд, лам, язгууртнууд эрхт төр, тусгаар оршихуй, монголчууд бид өөрийн газар шорооныхоо эзэн байх ёстой гэсэн үзэл санааны нэгэн сэтгэлэгт байдалтайгаар нэгдэн тэмцсэний дүнд 1911 оны өвөл цагаас Монгол орон харьцангуй бие даан, өөртөө туурга тусгаарласанаа зарлан тунхагласан билээ. Уг түүхэн үйл явдалд биечлэн оролцож, тэргүүлэн удирдсан монголын нөлөө бүхий лам, хар, хэн бүхэн дэмжин сайшааж хамтран зүтгэсэн ч Монгол улс өөртөө тусгаар тогтнолоо тунхаглан зарлаж төрийн цоо шинэ тогтолцоог бий болгон таван яамыг байгуулж, сайдын сэнтийд хувьсгалын хэрэгт тэргүүлэн оролцсон Ханддорж, Цэрэнчимэд, Чагдаржав зэрэг ноёд тохоон талбигдсаны маргаашнаац эхлээд л хэн хэнийгээ захирах вэ? гэсэн мөчөөрхөл ажиглагдах болсон. Тухайлбал, дотоод хэргийн бүгд захиран шийтгэх яамны тэргүүн сайд да лам Цэрэнчимэдийн бусадтай нэр хамталж дээш өргөсөн бичигт "...ээлэл тааллыг чухал болгон нөгөө дөрвөн яамыг дотоод яаманд бичиг илгээхдээ "өргөн" хэмээн мэдүүлж, харин дотоод яамнаас бусад яаманд "илгээн" хэмээн бичиж явбаас шүүмжлэл үгүй"¹ хэмээн Богд хаанд мэдүүлж "ёсоор болгуулсан" нь бусад сайдын дургүйцлийг төрүүлэх болсон юм. Энэ үед Хүрээнд сууж асан ерөнхий консул Любагийн Бээжинд мэдэгдсэн цахилгаанд "...Хүрээний сайд нарын хооронд сүрхий хурц зөрчил байна, засгийн хамаг эрх мэдлийг да лам тэргүүтэй харчина хэдэн түшмэл² гартаа авчээ"³ хэмээн мэдэгдсэн бол Нийслэл Хүрээнд Буриадын лам Агваандорж В.Котвичид бичсэн захидалдаа "энд да лам дотоод хэргийн министр болоод Хайсан гүн зэрэгтэй болж, энэ

* С.Чулуун. Монголын тусгаар тогтнол: ноёдын үхэл өгүүлэл нь Улс төрийн боловсролын академиас эрхлэн гаргадаг "Шинэ толь" хэмээх сэтгүүлийн 2000 оны №32. тал 181-186-д хэвлэгдсэн бөгөөд зохиогч тэр цагаас хойш сэдэвт хамаарах чухалд тооцогдох хэдэн баримтыг архиваас олсон ба хэвлэлээс хамаарах зарим нэг утгын болоод найруулгын алдааг засаж хэвлүүлж буй нь энэ.

¹ Монгол Улсын Үндэсний Төв Архив. (цаашид МУУТА хэмээн хураангуйлан бичнэ.) ФА-2, д.1, х/н-23. хуудас 53.

² Харчина хэдэн ноёд гэсэн нь Хайсан тэргүүтэй хэдэн хүнийг хэлж байна. Хайсан бол Өвөр Монголын Харчин гүн Гүнсэнноровын хошууны харьяат бөгөөд 1911 оны хувьсгалын хэрэгт үнэнхүү сэтгэлээр хичээн зүтгэсэн хэмээн Богд Жибзундамба хаанаас "...үе улиран чин зүтгэлт цол, улсад туслагч гүн, отто, хүрэн жолоо жич халхын дотор улаа шагнаж, дотоод яамны дэс түшмэлийн тушаалд" томилогдсон билээ.(МУУТА. ФА-1, д.1, х/н-1, нугалбар 3).

³ Международные отношения в эпоху империализма. Т. 2, М., 1938, стр 151.

хоёр их эрхтэй улс төрийн явдлыг тогтоож хаандаа юу айлтгасан түүгээр болж байна. Энэ нь бусад хаад, ноёдын сэргэлд тун тааламжгүй юу болох нь болзошгүй гэсэн ба Да лам Хайсан хоёрыг ч олноор зөвлөн зохилдон хэлэлцэх хэрэгтэй гэснийг нь ул хэрэглэнэ”¹ хэмээн бичицгээсэн байна.

Энэ нь Монголын төрийн ноёд, түшмэдийн хооронд ямар нэг хэмжээгээр засаглалын төлөөх тэмцэл эхнээсээ л ажиглагдах болсныг харуулж байна.

1911-1919 оны хооронд арав хүрээгүй жилийн дотор Монголын төрийг түшиж байсан томоохон улс төрийн зүтгэлтнүүд, хан, лам, ноёдууд тухайлбал Түшээт хан Дашиям 1912 оны 2 сард, Засагт хан Содномравдан 1912 оны 7 сард, Дотоод яамны дэд сайд Равдан 1913 оны 9 сард, бүгд ерөнхийлөн захирах яамны орлогч сайд Өвөр Монголын харьяат бинт Чин ван Гончигсүрэн 1914 оны 4 сарын 20-нд, Цэргийн яамны анхны сайд эрдэнэ далай ван Гомбосүрэн, 1914 оны 5 сард, Дотоод яамны тэргүүн сайд да лам Цэрэнчимэд 1914 оны 7 сард, Сангийн яамны анхны сайд түшээт ван Чагдаржав 1915 оны 7 сард, Ерөнхий сайд Т.Намнансүрэн 1919 оны 2 сард, мөн оны 7 дугаар сард Ерөнхий сайд эрдэнэ шанзуудба Бадамдорж зэрэг хүмүүс 27-50 гаруйхан насын хооронд нэн сэжигтэйгээр амь нас нь хохирчээ. Үүнийг архивын баримт бичигт тулгуурлан, учир шалтгааныг нь тодруулан судлах нь XX зууны эхэн үеийн улс төрийн амьдралын дүр төрхийн нэгзэхэн хэсгийн ямар нэг хэмжээгээр нэхэн тодлон гаргахад туслах нь дамжигүй. Учир нь Монголын тусгаар тогтолын төлөө тэмцэгч ноёдын амь нас ийм ахархан хугацаанд хохирсон нь түүхчдийн анхааралд бага сага төдий өртсөн ч судлаачид ихэвчлэн гадаад хоёр хөршийн зүгээс хайдаг бөгөөд дотоод хүчин зүйлийн тухайд анхааран судалсан нь багавтар юм. Мөн тэдгээр ноёдыг үнэхээр ямар нэгэн ашиг сонирхлын үүднээс амь насыг нь бүрэлгэв үү?, хэрвээ тийм зорилгоор бол яах гэж, хэний эрх ашгийн үүднээс эсвэл энэ хүмүүс нь идэр залуухан гучин хэдхэн насандаа гэнэт бие барцгаав уу?, ёс жамаараа юу?, гэсэн олон олон хариу нэхсэн асуулт хөврөнө. Гэхдээ бидний хувьд хэн нь хэнийгээ хорлов гэх зэрэг асуудлыг нэгзнт бүрнээ тодруулж чадахгүй нь ойлгомжтой, гагцхүү эдгээр хүмүүсийн нас барахынхаа өмнөх өөр хоорондын болон бусадтай харилцаж байсан байдал, тэдний амь насыг нь хороох онцгой шалтгаан гарч байсан уу, ямар үхлээр үхэв, энэ бүгд ямар үр дүнд хүргэв гэх зэргийн олон асуудлыг тодруулахыг оролдов.

Анх түрүүн 1911 онд Богд Жибзундамбыг хаан өргөмжлөх тухай санал халхын ноёдын дунд гаражад үндсэн хоёр санал байв. Бадамдорж тэргүүтэй хэсэг ноёд ихэсийн дийлэнх олонхи нь сүсэгтэн олны дунд Богд гэгээний нэр нөлөө ихийг харгалzan улсын хаан болгох, нөгөө хэсэг тухайлбал Ханддорж, шарын талын да лам Цэрэнчимэд нар Богд Жибзундамбыг бус харин Түшээт хан Дашиямыг улсын хаан болгох санал гарч нэлээд зөрөлдсөний эцэст дийлэнхийн санал төдийгүй тухайн үед ард олны дунд богдын нэр нөлөө хүчтэй байсан зэрэг олон хүчин зүйлээс хамаарч Богд Жибзундамбыг хаан ширээнд залах болжээ. Хаан залах их ёспол дээр хаан ширээнд албан ёсоор суух ёстой Дашиям “...Би бол энэ түүд гаралтай Жибзундамбыг бодвол их Чингис хааны угсааны дотроос хамгийн ахмад нь”² хэмээн өрсөлдөх санаа гаргажээ. Гэтэл энэ үед Дашиям дөнгөж 26 настай байсан тул ахмад гэдэг үгийг тэрээр ах насны ахмад биш, ахлах тэргүүлэх байр суурьтай гэсэн үүднээс хэлсэн нь илэрхий байна. Удалгүй Богд Жибзундамба хутагт өөрийн ордондоо урин залах үед буюу 1911 оны 2 сард Түшээт хан аймгийн түшээт ханы хошуунаас нийслэл Хүрээнд ирэх үедээ гэнэт бие барсныг "...Түшээт хан Дашиямын биед хуар өөчин

¹ Ж.Болдбаатар. Чин зүтгэлт гүн Хайсан. УБ., 2002, тал 24.

² Г.Навааннамжил. “Гадаад Монголын автономит үеийн түүх”. Хуучин монгол бичгээр. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн санд буй. тал 81.

тохиолдож эм гүрэм элдэвээр шавдан засуулсаар болоевт эдгэн чадсангүй¹ нас барлаа хэмээжээ. Энэ тухай Харбин хотноо хэвлэгддэг "Харбинский вестник" сонинд "...тушээт хан цэцэг өвчнөөр өвчилж үхэв" ² гэсэн бол оросын академич И.М.Майский "...Түшээт ханыг хорлуулж үхсэн яриа нутгийнхны дунд байна"³ гэх зэрээр тухайн үедээ олон янзаар тэмдэглэжээ. И.М.Майский бол Түшээт ханыг нас барсны дараахан буюу 1919 оны орчим Эрдэнэ зуу хавиар түүний хошууны нутгаар дайрахдаа дээрх мэдээг нутгийн ардуудын амнаас сонсож тэмдэглэсэн бололтой. Энэ бүгдээс үзэхэд Дашиам нь 26-хан насандaa жам ёсоороо таалал болсон бол энэ мэт олон таамаг, мэдээ, яриа гарах нь юу л бол. Ямар нэгэн сэжүүр санагдсан бололтой. Түүнийг нас барсны дараа Богд Жибзундамба хаанаас буулгасан зарлигын бичигт "...Зарлиг Дашиам чингэж бие өнгөрсөн нь үнэхээрийн хөөрхий их л нүгэлтэй тул түүний хойдлын буянд сангаас 100 лан мөнгө шагнай"⁴ хэмээжээ. Юутай ч түшээт ханы үхэл нь зүйгээр бус, гэхдээ манай судлаачдын үздэг шиг орос, хятадын талаас биш харин дотоод хүчин зүйлд хамааруулан үзвэл үнэнд илүү дөхөх нь лавтай бололтой.

Үнээс ердөө хоёрхон сарын дараа халхын дөрвөн ханы нэг Засагт хан Содномравдан гэнэт таалал болжээ. Түүний хэрхэн таалал болсон тухай нэгэн сонирхолтой дурдатгалд тулгуурлавал, Гандантэгчилэн хийдийн хамба асан түүхч, Эрдэнэпил агсны дуртагснаар "...1912 оны хавар Засагт хан таалал төгсөө. Нэг өдөр Дашчоймбол дацанд хурал хурж байсан бүх лам нарыг засагт ханы бие муудсан тул аваачиж ном уншуулсан юм. Маргааш өглөө нь засагт ханы харьяат нэгэн ламаас миний асуухад манай хан тэнгэр болов. Богдын ордонд бараалхаж очоод, тэнд хор зооглосон юм гэнэ. Тэгээд үнээний сүү уугаад тус болсонгүй нас эцэслэлээ"⁵ гэжээ. Энд анхаарал татах нэг зүйл бол түүний өвчнийг эдгэрүүлэхийн тулд сүү хэрэглэсэн нь гайхалтай. Өөрөөр хэлбэл хордсон байж магадгүй гэсэн үүднээс түүнд сүүний эмчилгээ хэрэглэсэн болов уу.

Дараагийн нэг анхаарал татах хүн нь Монгол улсын засгийн газрын орлогч сайд Өвөр Монголын харьяат, Бинт Чин ван Гончигсүрэн юм. Тэрээр Монгол төрийн тусгаар тогтолцоюн телөө нэгэн биеийг зориулж ажилласан нэгэн гарцаагүй мөн. 1913 онд да лам Цэрэнчимэдийн хамт Япон улсаас тусlamж гүйхаар явсан⁶ авч тодорхой хүчин зүйлээс хамаараад бүтэлгүйтсэн юм. Бинт чин ван Гончигсүрэн Монгол улсын төрийн зарим нэгэн алдаа зүйлд анхаарч шүүмжилж байсан нь ажиглагддаг. Тухайлбал, нас барахынхаа өмнөхөн Цэргийн яамны анхны сайд эрдэнэ далай ван Гомбосүрэнгийн үйл ажиллагаа сул, түүний сайжруулан ажиллуулахаар зургаан зүйлээр шүүмжлэн хэлэлцэхийг Богд хаанд айлтан өргөсөн бичиг өнөө хир архивын дансанд хадгалагдаж байна. Үүнийх нь хариуд далай ван Гомбосүрэн няцаасан хариу барьнаас хэдхэн хоногийн дараа түүнтэй заалдагч Бинт чин ван Гончигсүрэн гэнэт нас барсан⁷ бол төд удалгүй Эрдэнэ далай ван Гомбосүрэн "өөчний учир таалал төгссөн нь"⁸ нь сэжигтэй үхлүүдийн нэг мөн бөгөөд ямар нэгэн хөндлөнгийн этгээд тэдний харилцааны зөрчлийн учигийг овжин ашигласан

¹ Г.Навааннамжил. "Гадаад Монголын автономит үеийн түүх"..., тал 81(6).

² "Харбинский вестник". г. Харбин, 1912., №24.

³ И.М.Майский. Современная Монголия. Иркутск, 1912. стр 175.

⁴ МУУТА. ФА-47, д.1, х/н-6, тал 1.

⁵ С.Пүрэвжав. Монголын шарын шашны хураангуй түүх. УБ., 1970. тал 126.

⁶ Ц.Батбаяр. Японы эх газрын бодлого, гадаад монголын талаарх японы сонирхол. //Монгол Японы харилцаа: эрт эдүгээ. УБ., 2001. тал 49.

⁷ МУУТА. ФА-47, д.1, х/н-6, тал 1.

⁸ МУУТА. ФА-173. д.1, х/н-138, тал 3.

байна. Сонирхолтой нь яг энэ үед да лам дотоод яамны сайд Цэрэнчимэд баруун хязгаарт томилогдон явах үедээ одоогийн Увс аймгийн нутагт "хуучин өвчин үгдэрч хөдөлсөн нь замын зуур эмчлүүлэн шлааршсангүй боловч зарлигийг хүндэтгэн дагаж хэрхэвч уг хэрэгт хүрэх газарт хүрмий хэмээн хатамжлан явсаар.. Дэжээлэн хүрээний газарт буудаллаж эм гүрмээр шаардан шамдаж байсан ч хаван үүссэн ч гайгүй хэмээн хүрэх газарт хүрч улсын зах хязгаарыг үзэж оноосон албаан дуусгаж Богд эзний туйлын таалалд нийцүүлэн чадмой хэмээсээр энэ сарын шинийн долоонд тахиа цагт сайд...улс төрийн албыг дуусгаж чадсан үгүй нь үнэхээрийн хайран нулимын цувруулан дахин дахин гэрээслэн хэлж гэнэт амьсгал татаж насан нөгчив"¹ гэжээ. Энэ үед түүний тулах түшмэлээр ажиллаж байсан Г.Наваанамжил "...да лам Цэрэнчимэдийг зарлигаар тохоон явуулжээ. Энэ нь ч наагуураа баруун хязгаарыг тохинуулах хэргийг чухал болгосон хэрэг мэт боловч, цаагуураа Сайн ноён ханы зэрэг хар сайдууд нь улс төрийн ажил дээрээ ямагт алдагдлыг гаргах учир да ламаас элдэвт залруулах, ятгах, эсэргүүцэх, зөрөлдөх зэргийн нийлэмжгүй явдлаас түр зуур ч боловч баруун хязгаарт түлхэж зайлцуулахыг бодсон ажээ"². Үнэхээр ч сайн ноён хан Намнансүрэн, да лам Цэрэнчимэдийн хооронд бага сага зөрчил байсан юм. Тэр нь сайн ноён хан, ерөнхий сайд Намнансүрэн хаант Оросод 1913 онд айлчлахдаа Оросын санхүүгийн зөвлөхийг Монголд ажиллуулахыг зөвшөөрсөн нь хэзээнээс улс тэр, эдийн засгийн хувьд биеэ даан орших арга замыг баригч да ламд илт таалагдаагүй нь лавтай. Гэхдээ Ерөнхий сайд Намнансүрэн хүн хороох хүн отоос биш гэсэн саналыг зарим эрдэмтэд хийсэн нь бий. Энэ нь ч үнэний хувьтай. Харин Да ламын үхэл үнэхээр сэжигтэй санагдвал ёстой гадаад хүчин зүйлээс хайх нь зөв. Ялангуяа тэр Хаант Оростой эдийн засгийн асуудал дээр эрс сөргөлдөж байв. Оросын төлөөлөгч И.Я.Коростовиц гадаад яамны сайд С.Д.Сазановт "...да лам оростой ойртохыг эсэргүүцдэг манай хамгийн том дайсан бөгөөд биднийг Монголыг боолчлохыг эрмэлzsэн хэмээн буруутгаж байна, түүнийг засгаас зайлцуулах хэрэгтэй"³ гэж 1912 оны эцэст мэдэгдсэн байна. Да ламын дараагийн эзлжинд тухайн үеийн нөлөө бүхий улс төрийн зүтгэлтэн чин ван Ханддорж байв. Чин ван Ханддорж 1915 оны хавар шинийн зургаанд Богд хаанд золгохоор очсоны маргааш дунд голын месөн дээр харамсалтайгаар бусдад хорлогдсоныг архивын баримтанд "мориноос унаж нас барсан"⁴ гэдэг юм. Мөн л хааны ордонд зочилсны дараа далд аллагын суманд өртсөн байна. Түүний үхлийн тухай эрдэмтэд үзэхдээ Богд Жибзундамба болон Бадамдорж нарын хамт алсан гэсэн байхад, хятадын судлаачид оросод үнэнч ноход түүнийг алсан гэж үзэцгээсэн нь магадлал багатай юм. Тухайлбал, Богд хаан түүнийг нас барсныг сонсоод асар их гашуудан эмгэнэж байсан ба түүнтэй анхнаасаа хамtran тэмцэж, зүтгэж явсан ба хорлох үндэслэл бага юм, хоёрдугаарт Ханддорж бол Оросын талыг хамгийн ихээр баригч зүтгэлтэний нэг. Тиймээс энэ хоёр дүгнэлт нь баталгаа багатай.

Тухайн үеийн улс төрийн зүтгэлтнүүдээс ихээхэн сэжиг бүхий хороогдсон хүний нэг нь Түшээт гүн сангийн хамаг хэргийг бүгд захирах яамны сайд Г.Чагдаржав юм. Г.Чагдаржав нь Монгол улсын хувь заяаг шийдэх хамгийн эзэгтэй, ээдрээтэй нөхцөл байдалд Орос, Хятад хоёр улстай туштай есөн сар гаруй чи бидээ тулж, сөрж сөргөлдөж, эвлэж зөвлөлдсөний эцэст Монгол улс өөртөө засах эрхтэй үлдсэн нь томоохон амжилт байсан юм. Г.Чагдаржав

¹ МУУТА. ФА-141, д.1, х/н-33, тал-25.

² Г.Наваанамжил. Өвгөн бичээчийн өгүүлэл. УБ., 1959. тал-201.

³ Международные отношения в эпоху империализма. Т. 20, М., 1938, стр 471.

⁴ МУУТА. ФА-73, д.1, х/н-139, тал 10.

Хиагтын хэлэлцээрээс ирсний ердөө сарын дараа дээш өргөсөн нэгэн бичигт "...Шавь боол Чагдаржав миний биед энэ зуны сүүл сараас эхлэн дээш хөөрч амьсгал давчих ба хүчтэй ханиалгах зэрэг өвчин тохиолдсон нь элдэвээр шавдан засуулсаар боловч илаарших төлөв үгүй нэн дордон маш зовиур бүхий хэвтэж буй ану. . . . өвчинийг чөлөө шагнан олгоно уу"¹ хэмээн гүйж чөлөө аваад 11 хоногийн дараа ". ..Чагдаржавын өвчинийг шаардан засуулсан боловч илаар болон чадсангүй улам хүндээсээр энэ долоон сарын 16-ны хулгана цагт нэгэнт наснаас нөгчив"² гэжээ.

Инхүү тэргүүн сайдууд болох Ханддорж, Цэрэнчимэд, Гомбосүрэн, Чагдаржав, Гончигсүрэн болон Содномравдан, Дашням зэрэг хануудыг хөнөөсөн аллага эцсийн сум Монгол улсын ерөнхий сайд, сайн ноён хан Намнансүрэнд тусах нь гарцаагүй болсон гэж үзэх бүрэн үндэслэл байна. Намнансүрэнг хэдийвээр архивын баримтанд өвчнөөр нас эцэслэсэн гэж бичсэн ч үнэн байдал тийм биш бололтой. Бодохул, Монгол улсын төрд үлдээд байсан хамгийн нөлөө бүхий улс төрийн зүтгэлтэн энэ хүн бараг ганцаардаад байлаа. Энэ үед Монгол Улсын төрийн тусгаар тогтолцоог оршихуу, эс оршихуу гэдэг хамгийн эгзэгтэй үед Хятадын эрхэнд орохыг эсэргүүцэх хамгийн гол саад болох хүн нь Намнансүрэн байсан юм. Түүний учир битүүлэг байдлаар нас барсан гэдгийг батлах өөр нэгэн баримт болох Буриад зоны нэгэн бичигт "... Богд Чингис хааны язгуур үндэсний үр, маш ариун тунгалааг оюунт ерөнхий сайд сайн ноён ханыг хорлогсон нь даан ч өнгөргүй, муу хоронд хамаг бие нь шарлаж хилсээр өөд болсон"³ гэсэн ба Д.Боддоо, Д.Догсом нараас 1920 онд Коминтерний Алс дорнодын нарийн бичгийн дарга нарын газарт өргөсөн бичигт: ". . .Бээжин засгийн газрын ховдог харгис эзэлт эрх баригчид сайн ноён хан мэтийн үнэнхүү сайдуудыг хороор алж арилгав"⁴ гэж бичсэн хоёр баримтаас үзвэл гадаад хүчин зүйлээс хамааралтай мэт байна.

Эцэст нь тэмдэглэхэд:

1. Олноо өргөгдсөн Монгол Улсын төрийн зүтгэлтнүүдийн дунд эрх ашиг, нэр тэр, албан тушаалын зөрчил ямар нэг байдлаар илэрхий байсан нь архивын эх хэрэглэгдэхүүн, баримт сэлтээс тодорхой байна.
2. Тухайн үеийн тэргүүлэх ноёд, лам нарын хооронд гарсан эдгээр зөрчил нь гадаадын элдэв хүчин болон дотоодын зүгээс олзлон ашиглагдаж улмаар тэдний амь насыг нь элдэв нууц байдалтайгаар хороох явдал байсан бололтой.
3. Монгол төрийн тусгаар тогтолцын төлөө нэгэн биеийг зориулан хамтран тэмцэж байсан нэгэн үеийн улс төрчид маань учир битүүлгээр таалал төгссөн нь Монгол орны цаашдын хувь заяанд нь нөлөөлөхгүй байж чадаагүй юм. Үүнийг илэрхийлэх зарим архивын баримт бичгүүд нь шинжлэх ухааны эргэлтэнд анх орж буйгаараа сонирхол татаж болохуйц юм.
4. Цаашид тухайн асуудлыг олон шинжлэх ухааны нарийн онол арга зүй, зарчмаар баримтыг уялдуулан буйлуулж судалвал ХХ зууны эхэн үеийн монголын улс төрийн амьдралын нэн сонин дүр зураг гаргаж чадах бөгөөд энэ бүгд нь Монгол орны ирээдүйн түүхэнд түүхэн сургамжийн ач холбогдолтой асуудал мөнөөсөө мөн.

¹ МУУТА. ФА-173, д.1, х/н-138, тал 39.

² МУУТА. ФА-173, д.1, х/н-141, тал 19.

³ Тусгаар тогтолцон. УБ., 1991, 6 сарын 4-ний дугаар.

⁴ Үнэн сонин. 1989 он. УБ., 7 сарын 11-ний дугаарт. хуудас 3.